

## Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны 3 дугаар сарын байдлаар)

### I. Нийгмийн үзүүлэлт



#### I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2016 оны 3 дугаар сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1397 болж, 2015 мөн үеэс 828 хүнээр өсч, өмнөх сарынхаас 141 хүнээр буурав.

Ажилгүйчүүдийн 46.6 хувь буюу 651 нь эмэгтэйчүүд юм. 2016 оны эхнээс 229 ажлын байр захиалгад бүртгэгдсэн бол зуучлалаар 169 ажлын байранд иргэд ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 42.01 хувь буюу 71 нь эмэгтэйчүүд байв.

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 3 дугаар сарын эцсийн байдлаар, өссөн дүнгээр



Тайлант сард бүртгүүлсэн 343 ажилгүй иргэний 26.82 хувь нь сургуулиа төгссөн, чөлөө авсан; 16.32 хувь нь цалин орлого хүрэлцэхгүй байгаа; 13.41 хувь нь мэргэжил ур чадвараа ашиглан орлогоо нэмэгдүүлэх; 9.33 хувь нь шилжин суурьшсан; 6.41 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон; 5.54 хувь нь орон тооны цомхтголд орсон; 3.5 хувь нь цэргээс халагдсан; 2.62 хувь нь одоо эрхэлж

байгаа ажлаа солих хүсэлтэй; 2.62 хувь нь гүйцэтгэж буй ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон; 1.45 хувь нь байгууллага татан буугдсан; 1.17 хувь нь гадаадаас эргэж ирсэн; 0.58 хувь нь хорих газраас суллагдсан; 10.20 хувь нь бусад шалтгаанаар тус тус бүртгүүлжээ.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2016 оны 3 дугаар сарын эцэст



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

\*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



#### I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 3 сард НДШ-ийн орлого 3.80 тэрбум ₮ болж төлөвлөгөө 99.26 хувь болж, төлөвлөгөөг 20 сум 3.82-63.89 хувиар давуулан биелүүлж. Архуст, Батсүмбэр, Баян, Баянчандмань, Борнуур, Эрдэнэ, Зуунмод сумд 1.54-63.31 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 260.5 сая ₮ болж төлөвлөгөөг 100 хувь биелүүллээ.

Тэтгэвэр, тэтгэмжинд 9.67 тэрбум ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо.

Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.9 хувийг өндөр настны, 10.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.8 хувийг тэжээгчээ алдсаны, 5.1 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 264710 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 36.30 хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 22.38%; тэтгэмжийн даатгалын сангийн 81.05%; эрүүл мэндийн даатгалын сангийн 156.98%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 80.69%; ажилгүйдлийн даатгалын сангийн 83.79%-ийг тус бүр бүрдүүлжээ.

### Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 3 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 47869 хүнд олгож, 4.2 тэрбум ₮-ийг зарцуулж 2015 оны мөн үеэс хүний тоо 1.04 хувь 507 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 20.23 хувь 711.9 сая ₮-өөр тус бүр буурлаа.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 106040 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 45.27 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 16.64 хувийг халамжийн тэтгэвэр; 5.88 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 4.63 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 1.33 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 2.05 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж 0.56 хувийг алдар цолтой

ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




### 1.3 Эрүүл мэнд

2016 оны эхний 3 сард 4549 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.54 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 3 сард 294 хүүхэд мэндэлсэн нь 2015 оны мөн үеэс 8 хүүхдээр буурлаа

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



Аймгийн хэмжээнд он гарсаар 1 хүртэлх насандаа нас барсан хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 10 хүүхдээр өслөө.

Зураг 1.4


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



2016 оны эхний 3 сард халдварт өвчнөөр 358 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 1.3 дахин буюу 207 хүнээр өслөө. 2015 оны мөн үеэс заг хүйтэн 1.1 дахин, салхин цэцэг 1.05 дахин, вируст хепатит 3.0 дахин, тэмбүү 2.17 хувь, сүрьеэ 9.37 хувь тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох халдварт өвчлөл аймгийн дундаж 39 байгаа бол: Зуунмод 119, Баян-Өнжүүлд 104, Угтаал 60, Архуст 55, Сүмбэр 45 ногдлоо.

Зураг 1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



#### 1.4 Байгаль орчин

Цаг агаарын тойм, агаарын бохирдол

Төв аймгийн 2016 оны 3 сарын цаг агаарын байдлыг

олон жилийн дундажтай харьцуулсан тойм

-агаарын дундаж температур 3-7 градус хүйтэн буюу нутгийн баруун өмнөд хэсгээр үүнээс Дэлгэрхаан дулаан, нутгийн зүүн хэсэг, Мөнгөнморьт орчмоор хүйтэн

- өдрийн агаарын хамгийн дулаан температур +12+18 градус, Зуунмод, Эрдэнэ болон

нутгийн зүүн хэсгээр хүйтэн, Өндөрширээт, баруун өмнөд хэсгээр дулаан байна.

-шөнийн хамгийн хүйтэн температур 24-35 градус хүйтэн, Баянцагаан, нутгийн өмнөд хэсэг дулаан, Батсүмбэр, голын хөндийгөөр 30-35 градус буюу хамгийн хүйтэн байв.

-сарын нийлбэр хур тунадас 1.8-18,9 мм буюу ихэнх нутгаар ахиу цас оржээ. Хамгийн их нь Зуунмод орчмоор 18,9 мм, Лүн 15,7 мм, Баянчандмань 13,2 мм цас орж, харин нутгийн өмнөд хэсгээр бага хур тунадас оржээ.

-салхины хурд ихэнх хугацаанд бүх нутгаар 3-8 м/с, 04-нд 10-15 м/с, ихэнх нутгаар 20-24 м/с, түр зуур 29 м/с хүрч, хүчтэй цасан болон шороон шуурга шуурлаа байна.

Олон жилийн дундажтай харьцуулсан дүгнэлт

-агаарын дундаж температур нь нийт нутгаар 0-3 градусаар дулаан

-өдрийн хамгийн их температур 1-5 градусаар хүйтэн буюу ойролцоо,

-шөнийн хамгийн бага температур ихэнх нутгаар 1-5 градусаар хүйтэн буюу ойролцоо

-хур тунадасны нийлбэр ихэнх нутгаар 0,1-13,7 мм-ээр ахиу, Алтанбулаг, Баянцагаан,

Мөнгөнморьт, Өндөрширээт орчмоор өмнөх жилээс бага, нутгийн хойд хэсгээр ахиу үүнээс Зуунмод, Лүн, Баянчандмань Жаргалант, Батсүмбэр орчмоор бусад сумдаас их цас оржээ.

-салхины их хурд 10-15 м/с, ихэнх нутгаар 20-24 м/с, түр зуур 27-29 м/с хүрч, цас орох үеэр хүчтэй цасан болон шороон шуурга шуурлаа.

2016 оны 3-р сар нь өмнөх оны тухайн сараас хүйтэн байсан нь агаарын дундаж

температураас харагдаж байна. 1-р арав хоногт нийт нутгаар 0,6-14,2 мм цас орж, 0-23 см цасан бүрхүүлтэй байгаа нь өмнөх оноос цас ихтэй, сарын эхээр гамшигт үзэгдлийн хэмжээнд хүрсэн хүчтэй салхи шуургатай, хүйтэн цаг агаар тогтворгүй байлаа.

Сарын 1-р арав хоногийн эхний хагас, сүүлч, /1-4, 7-10-нд/, 2-р арав хоногийн эхэн, дундуур /11, 15-16, 20-21нд/ хүйтэрч, температурын огцом хэлбэлзэл ихтэй байлаа. Хүйтрэх үедээ өдөртөө бүх нутгаар 8-14 градус, шөнөдөө 20-30 градус хүйтэн байв. 5-6, 12-13, 18-19-нд хүйтний эрч суларч, ялангуяа 22-ноос эхлэн 24-25-нд нилээд дулаарч, шөнөдөө ихэнх хугацаанд нийт нутгаар 1-10 градус хүйтэн, өдөртөө нутгийн зүүн хойд хэсгээр 12-17 градус, бусад нутгаар 17-22 градус дулаан байлаа.

#### 2016 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

Энэ сард агаарын дундаж температур уулархаг нутгаар 4 градус хүйтнээс 1 градус дулаан, бусад нутгаар 2-7 градус дулаан байх дунджийн орчим байх төлөвтэй.

Хүйтрэх үе. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёдугаар арав хоногийн дунд үе ба сүүлчээр хүйтэрч, уулархаг нутгаар шөнөдөө 11-16 градус, өдөртөө 0-5 градус хүйтэн, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус хүйтэн, өдөртөө 1-6 градус дулаан байна. Сарын эцсээр хүйтэрнэ.

Дулаарах үе. Харин нэг ба гуравдугаар арав хоногийн дунд үеэр харьцангуй дулаарч

шөнөдөө уулархаг нутгаар 2-7 градус хүйтэн, бусад нутгаар 1 градус хүйтнээс 4 градус дулаан, өдөртөө голын хөндийгөөр 19-24 градус, бусад нутгаар 15-20 градус дулаан байна.

Бусад хугацаанд. Уулархаг нутгаар шөнөдөө 6-11 градус хүйтэн, өдөртөө 5-10 градус дулаан, бусад нутгаар шөнөдөө 1-6 градус хүйтэн, өдөртөө 11-16 градус дулаан байна.

Энэ сард орох хур тунадасны хэмжээ нь Төв аймгийн баруун хэсгээр уур амьсгалын дунджаас бага, бусад нутгаар олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй. Нэгдүгээр арав хоногийн эхээр зарим газраар, сүүлчээр нь ихэнх нутгаар цас, хоёрдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр зарим нутгаар, гуравдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн хойд хэсгээр, сарын эцсээр ихэнх нутгаар хур тунадас, уулархаг нутгаар нойтон цас орох төлөвтэй. Энэ үеүдэд салхи зарим газраар 14-16м/с, ялангуяа нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёр ба гуравдугаар арав хоногийн дунд үе болон сүүлчээр нутгийн өмнөд хэсгээр 18-20 м/с хүртэл ширүүсч шороон ба цасан шуурга шуурна.

#### ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

4 дүгээр сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр агаарын дундаж температур нутгийн нутгийн баруун өмнөд хагаст дунджаас дулаан, бусад нутагт дунджийн орчим, хур тунадас ихэнх нутагт олон жилийн дунджийн орчим ба түүнээс бага, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутаг болон говийн нутгийн өмнөд хэсгээр дунджаас ахиу орох төлөвтэй байна. 4 дүгээр сард дулаан, тунадас ахиу орох төлөвтэй нутгаар бэлчээрийн ургамал эрт цухуйж, хөрс эрт гэсэж газар тариаланд таатай нөөлөлөхөөр байна. Түүнчлэн 4 дүгээр

сард үе үе хүчтэй цасан болон шороон шуурга шуурч малын хариулга маллагаа болон төл хүлээн авахад хүндрэл учруулж болзошгүйг онцгой анхаарна уу.

### 2016 ОНЫ ТАВДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН ТӨЛӨВ

Энэ сарын агаарын дундаж температур нь аймгийн зүүн хэсгээр 5-9, бусад хэсгээр 10-15 градус дулаан буюу ихэнх нутгаар олон жилийн дунджийн орчим байна. Энэ сард Төв аймгийн хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй.




#### 1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2016 оны эхний 3 сард аймгийн хэмжээнд 249 гэмт хэрэг бүртгэгдэж 177 хүн холбогдож иргэдийн өмчид 589.2 сая ₮-ийн хохирол учирлаа.


Зураг 1.8

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар




Гарсан гэмт хэргийн 31.7 хувь нь хулгай, 22.5 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний эсрэг хэрэг, 0.0 хувь нь замын осол, 3.9 хувь нь танхай дээрэм, 0.8 хувь нь хүн амины хэрэг, 0.0 хувь нь өмчийн, 4.4 хувь нь бусад хэрэг тус бүр эзлэв. Баянжаргалан, Аргалант, Батсүмбэр, Заамар сумдад 18 дээш насны 10000 хүнд 108-83 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (28)-аас их гарлаа.

Гэмт хэргийн тоо 2015 оны мөн үеэс 20 хэргээр буурлаа.

Зураг 1.10

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



Гарсан гэмт хэргийн 30.5 хувь нь бүлгээр; 30.5 хувь нь согтуугаар үйлдэгджээ. Гэмт хэргийн улмаас 12 хүн нас барж, 72 хүн гэмтлээ



## Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2016 оны эхний 3 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа 342 гүйцэтгэх хуудсанд нийт 1.98 тэрбум ₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 3 гүйцэтгэх хуудсанд ногдох 146.5 сая ₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 339 гүйцэтгэх хуудасны 1.83 тэрбум ₮-өөс 90 хуудасны 167.5 сая ₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 26.55 хувь, үнийн дүнгээр 9.13 хувь болж 2015 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 4.92 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 10.96 нэгжээр тус тус буурлаа.

## II. Эдийн засгийн үзүүлэлт



### II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбаруудын дүнгээр 2016 оны эхний 3 сард кассын орлого 96.2 тэрбум ₮, кассын зарлага 96.5 тэрбум ₮ болж, гүйлгээнд 91.9 тэрбум ₮ байна.

ХААН, Хас, Төрийн, Капитал банкны салбарын нийт зээлийн багц зээлдэгчийн тоо 63799, зээлийн багцын дүн 200.9 тэрбум ₮, зээл авсан зээлдэгчийн тоо 19559, олгосон зээлийн дүн 31.1 тэрбум ₮ боллоо. Иргэдийн хувийн хадгаламжинд 3 сарын 31-ний байдлаар хугацаатай хадгаламж 39.5 тэрбум ₮, хугацаагүй хадгаламж 8.6 тэрбум ₮ байна. Ирэгдийн харилцах дансны үлдэгдэл 3 сарын 31-ны байдлаар 176888 иргэний 5.6 тэрбум ₮ боллоо.

ХААН, Төрийн, Хас, Капитал банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 0.76-1.39 хувь, хугацаатай доод хүү 0.50-0.60 хувь, хугацаагүй дээд хүү 0.60-0.61 хувь, хугацаагүй доод хүү 0.50-0.60 хувьтай байна.



### II.2 Төсөв, мөнгө

Аймгийн төсвийн орлого 2015 оны мөн үеэс 30.98 хувь буюу 481.4 сая ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 91.15 хувийг татварын, 8.3 хувийг татварын бус, 0.59 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2015 оны мөн үеэс татварын орлого 16.5 нэгжээр өсч, татварын бус орлого 16,8 нэгжээр буурч, хөрөнгө борлуулсны орлого 0.3 нэгжээр өслөө.

Аймгийн нийт 3 шатны орлого 2307.8 сая ₮ болж аймгийнх 1834.9 сая ₮ буюу 79.51 хувь, сумынх 200.4 сая ₮ буюу 8.68 хувь, улсынх 272.5 сая ₮ буюу 11.81 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2015 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 34.8 хувь буюу 293.1 сая ₮-өөр өсч 1134.3 сая ₮ болж, авлага 5.5 хувь буюу 9.5 сая ₮-өөр буурч 163.5 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 2.1 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 90.35 хувиар биелэгдэж. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 113.3 сая ₮ болж, төлөвлөгөө 69.70 хувь биелж, Алтанбулаг, Аргалант, Архуст, Батсүмбэр, Баян, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцагаан, Баянцогт, Дэлгэрхаан, Жаргалант, Заамар, Өндөрширээт, Сэргэлэн, Угтаал, Эрдэнэ, Эрдэнэсант, Зуунмод сумд 78.61-22.06 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 1.8 тэрбум ₮ болж 90.29 хувь биелж Алтанбулаг, Баян, Баянцагаан, Баянцогт, Борнуур, Жаргалант, Заамар, Өндөрширээт, Сүмбэр, Угтаал, Эрдэнэ, Зуунмод сумд төлөвлөгөө 38.19-1.48 хувиар тасалдууллаа.




### II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2016 оны 3 дугаар сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 64.57%, өмнөх оны мөн үеэс 6.37%, өмнөх сараас 1.24 хувиар тус тус өсөв.

Зураг II.4

Хэрэглээний үнийн аймгийн индекс (өмнөх оны 12 сар=100)



ХҮИ-ийн 2016 оны 3 дугаар сарын 1.24 хувийн өсөлтийн 0.77 нэгж нь хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн; 0.18 нэгж нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн; 0.18 нэгж нь гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн; 0.05 нэгж нь орон сууц, ус цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн; 0.04 нэгж нь тээврийн бүлгийн; 0.05 нэгж нь бусад бараа үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаав.

Бараа, үйлчилгээний бүлэг	2016 оны 3 сард	
	пунктээр	хувиар
Бүгд	1.24	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.77	62.13%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.00%
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	0.18	14.34%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.05	4.31%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.18	14.13%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
07. ТЭЭВЭР	0.04	2.93%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	-0.02	-1.75%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЕЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	-0.01	-0.97%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.01	1.06%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.05	3.82%



### II. Төл бойжилт

Гарсан төлийн 2.1 хувь 8651 болох толгой төл хорогдсон нь урьд оны мөн үеэс 1.55 дахин буюу 5259 төлөөр өсч; 2007-2015 оны мөн үеүдийн дунджаас 22.33 хувь буюу 2488 төлөөр буурлаа. Гарсан унаганы 7.4, тугалын 4.0, хурганы 1.7, ишигний 2.4 хувь нь тус бүр хорогдов. Хамгийн их хорогдолтой 5 сум Алтанбулаг, Лүн, Сэргэлэн, Угтаал, Эрдэнэсант сумд гарсан төлийнхөө 3.6-2.2 хувь буюу 1801-638 төл хорогдуулсан нь аймгийн бүх төлийн хорогдлын 60.3 хувийг (бүгд 5217 төл) эзлэв.

4 сарын 1-ний байдлаар оны эхний малын 1.24 хувь буюу 55279 том мал зүй бусаар хорогдсон нь 2015 оны мөн үеэс 16.3 дахин буюу 52079 толгойгоор; 2007-2015 оны мөн үеүдийн дунджаас 9.8 хувь буюу 4943 толгойгоор тус бүр өслөө. Хамгийн их хорогдолтой 5 сум Лүн, Баян-Өнжүүл, Угтаал, Бүрэн, Эрдэнэсант сумд оны эхний малынхаа 0.56-0.18 хувь буюу 7867-3854 том мал зүй бусаар хорогдуулсан нь аймгийн бүх хорогдлын 49.7 хувийг (бүгд 27515) эзлэв.

Оны эхний тэмээний 0.41, адууны 0.98; үхрийн 1.68; хонины 0.96; ямааны 1.62 хувь нь тус бүр хорогдов. Бүх зүй бусаар хорогдсон малын 2.59 хувь нь өвчнөөр, 31.1 хувь нь хээлтэгч мал эзлэв.

нь өвчнөөр, 29.52 хувь нь хээлтэгч мал эзлэв.



## II.5 Аж үйлдвэр

2016 оны эхний 3 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 1.04 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2015 оны мөн үеэс 45.1 хувь буюу 863.4 сая ₮-өөр буурлаа.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр

АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, сая.₮  
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2015 III	2016 III	2015 I-III	2016 I-III	Дүнд эзлэх % Percentage share to total		2016% 2015%
					2015 I-III	2016 I-III	
Нийт дүн Ашигт малтмал олборлолт mining and quarrying	503.47	321.07	1,912.63	1,049.22	100.0	100.0	54.9%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/ Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	180.47	106.32	1,115.32	474.27	58.31	45.20	42.5%
	250.69	207.51	725.01	559.93	37.9	53.37	77.2%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсан нь арьс шир боловсруулах, үслэг арьс боловсруулалт, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл, хэвлэн нийтлэх, цахилгаан дулааны үйлдвэрлэл өмнөх оноос 92.6-8.7 хувь буюу 411.69-5.15 сая ₮-өөр буурсан нь нөлөөлөв.


Зураг II.6

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Зуунмод, Баянцогт, Батсүмбэр, Эрдэнэ, Баянцагаан, Угтаалцайдам сумд 55.69-2.01 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 80.1) хувийг

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, хувиар



## II.7 Холбоо


Холбоо ашиглалтын орлого эхний 3 сард 44.6 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 20.5 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.17 хувь буюу 766.4 мянган ₮ өөр өслөө.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 25.9 сая ₮ болж, нийт орлогын 77.9 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 22.01 хувийг албан бичгийн, 13.52 хувийг зорчигчдын, 64.47 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.10

Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр





### Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл.

Аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 3 сард нийт 2177 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд баталгаажуулалтыг хийж 12.3 сая ₮-ийн орлого орууллаа.

Нийт орлогын 38.3 хувийг зээлийн барьцаанаас, 35.3 хувийг газар өмчлөлийн үйлчилгээнээс, 3.3 хувийг хувийн орон сууц, хашаа, байшингаас, 3.2 хувийг худалдааны үйлчилгээнээс, 5.2 хувийг бэлэглэлээс 0.3 хувийг өв залгамжлалаас, 0.3 хувийг арилжаанаас тус бүр оруулжээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 3 сард нийт 777 иргэд, аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгөд бүртгэл хийснээс үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн анхны бүртгэл 46; төрөөс үнэгүй өмчлүүлсэн газрын өмчлөх эрхийн анхны бүртгэл 400; газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 1; бэлэглэлийн гэрээ 17; худалдах, худалдан авах гэрээ 36; өв залгамжлал 7; барьцааны гэрээ 184; бусад бүртгэл 86 тус бүр бүртгүүлжээ.

Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээгээр 2016 оны эхний 3 сард нийт 37 аж ахуйн нэгж шинээр бүртгүүлснээс хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ХХК/ 22 ; нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага /НҮТББ/ 6; шашин 2; боловсрол сургалтын байгууллага /БСБ/ 1; гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага /ГҮТББ/ 4; Төсөвт 2 тус бүр бүртгүүлжээ.

Хуулийн этгээдийн бүртгэлийн 2016 оны 3 сарын мэдээгээр 76 аж ахуй нэгж байгууллага нэмэлт өөрчлөлт хийлгэснээс үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 11; гишүүн нэмэгдсэн, хасагдсан 16; дүрэм шинчилсэн 3; дахин гэрчилгээ 3; удирдлага өөрчлөгдсөн 12; үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн 8; дүрмийн сан нэмэгдсэн, хасагдсан 10; хаяг өөрчлөгдсөн 1; татан буугдсан 8; тус бүр бүртгүүлжээ. Мөн 22 иргэн, 6 хуулийн этгээдэд лавлагаа олголоо.

### Аудит

Аймгийн аудитын газар 2016 оны эхний 3 сард 183 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийснээс 164 нь зөрчилгүй, 17 нь хязгаарлалттай, 1 сөрөг, 1 нь санал дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлтүүдтэй гарлаа. Аудитын үйлчилгээний төлбөр 66.3 сая ₮ оруулахаас, орон нутгийн төсөвт 41.8 сая ₮-ийг орууллаа. Тайлангийн хугацаанд 4938.3 сая ₮-ийн 116 төлбөрийн акт, албан шаардлагыг тавьж 5.7 сая ₮-ийн 2-г барагдуулсан нь биелэлтийн хувь тоогоор 1.72, үнийн дүнгээр 0.12 хувьтай гарлаа.

### Стандартчилал хэмжилзүй

Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн 2016 оны эхний 3 сарын мэдээгээр нийт 42 аж ахуй нэгж иргэнд стандартын салбар сангийн үйлчилгээ үзүүлснээс тохирлын баталгаажуулалт 101; үүнээс тохирлын гэрчилгээ 81, дотоодын бүтээгдэхүүний

баталгаажуулалт 20; хэмжих хэрэгслийн баталгаажуулалт 267; үүнээс цулын хэмжүүр 112, жин 83, туухай 29; эзэлхүүн зарцуулалтын хэмжүүр 37; үүнээс түгээгүүрийн хэмжүүр 24, сүмбэн метр 2, усны тоолуур 11; нэг фазын тоолуур 118, даралтны аппарат 5 тус бүр баталгаажуулсан байна.

#### Мал эмнэлэг

Мал эмнэлгийн бүх төрлийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2016 оны эхний 3 сард 855.0 мянган толгой мал хамрагдсан нь 2015 оны мөн үеэс 7.8 дахин буюу 757.6 мянган толгойгоор өслөө. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ халдварт өвчнийх 9.80 хувийн гүйцэтгэлтэй биелэгдлээ.